

М.Болд: Мөнгөний ялгавартай бодлого явуулах шаардлагатай

Монголын банкуудын холбооны VI чуулган өнгөрсөн баасан гаригт боллоо. Уг чуулганд банк, санхүүгийн байгууллагын төлөөлөгчид хуран цугларч, өнгөрсөн жилийн ололт, амжилт, алдаа дутагдлаа дүгнэж хэлэлцэн, холбооныхоо шинэ ерөнхийлөгчийг сонгов. “Тэнгэр” санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал Магваны Болд олонхийн саналаар ерөнхийлөгчөөр сонгогдсон юм. Холбооны ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Д.Мэдрээ болон бусад хоёр хүнийг дэд ерөнхийлөгчөөр сонгосон юм. Чуулганы үеэр Монголын банкуудын холбооны шинэхэн ерөнхийлөгч М.БОЛДТОЙ ярилцлаа. Тэрээр өмнө нь Монголбанкны дэд ерөнхийлөгч, “Хас” банкны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.

-Юуны өмнө холбооныхоо ерөнхийлөгчөөр сонгогдсонд тань баяр хүргэе. Шинэ он гарах дөхөж байна. Өнгөрсөн жил танай холбоо хэр ололт, амжилттай ажиллав. Ер нь Монголын банкуудын холбоо банк санхүүгийн салбарт ямар үүрэгтэй оролцдог вэ?

-Монголын банкуудын холбооны гол зорилго Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банк, санхүүгийн байгууллагуудын нийтлэг эрх ашгийг нэгдсэн байдлаар хамгаалахад оршиж байдаг. Банк санхүүгийн үйл ажиллагааг явуулах хууль эрхзүйн таатай орчин бүрдүүлэх тал дээр л гэхэд нэгдмэл сонирхолтой байдаг учраас холбоогоороо дамжуулж, УИХ, Засгийн газар холбогдох бусад байгууллагуудтай хамтарч ажилладаг. Нөгөөтэйгүүр, банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа явуулах зөөлөн дэд бүтцийг хамтарч байгуулах өөр нэг зорилготой. Зөөлөн дэд бүтэц гэдэг маань наад зах нь зээлийн мэдээллийн сан, зээлийн баталгааны сан, банк санхүүгийн салбарын ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, банк санхүүгийн академийг байгуулах гэх мэт. Цаашлаад үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг бүртгэх улсын систем зэрэг дэд бүтцүүдийг бий болгох тал дээр хамтарч ажилладаг. Дээр нь гадаадын байгууллагуудтай харилцах, Монголын банкны салбарыг гаднын түнш байгууллагуудад үнэн зөвөөр нь ойлгуулах, үнэлүүлэх асуудал бий. Манайхныг гаднын зэрэглэл тогтоох байгууллагууд, хөндлөнгийн аудитын байгууллагууд, шалгадаг явдал улам нэмэгдэж байна.

Өнгөрсөн жил энэ тал дээр нэлээд ажил хийсэн. Зээлийн мэдээллийн хууль батлуулж чадлаа. Шинээр Зээлийн батлан даалтын сан, банк санхүүгийн академи, орон сууцны санхүүжилтыг илүү хялбар, шуурхай болгох зорилготой хоёр дахь шатны байгууллага болох ипотекийн корпорацыг банкууд хамтарч байгууллаа. Зээлийн мэдээллийн төвийг байгууллахаар болж, ажил ид дундаа явж байна. Ерөнхийдөө банкууд зөвхөн өөр хоорондоо өрсөлдөх бус хамтарч ажиллах, хүчээ нэгтгэж нэгэн зорилгын төлөө явах үйл явц өрнөж байна.

-Та дэд ерөнхийлөгч байсан бол ерөнхийлөгч боллоо. Гурван ч дэд ерөнхийлөгчтэй нэлээд хүчирхэг багтай боллоо. Ирэх жил ямар ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?

-Нэгэнт эхлүүлсэн хууль эрхзүйн орчныг сайжруулах, банк санхүүгийн салбарын дэд бүтцийг улам боловсронгуй болгох ажлуудыг үргэлжлүүлнэ. Дээр нь

банк санхүүгийн байгууллагуудын ил тод байдлыг хангах, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт жишигт улам бүр ойртуулах ажлууд хийнэ гэж бодож байгаа.

-Таны бодлоор Монголын банк, санхүүгийн салбарын хөгжил ер нь аль төвшинд явж байна вэ. Түрүүн та “Стандарт энд Пурс”-ийнхэн Монголын банкны салбарт тун доогуур үнэлгээ өгчихөөд явсантай санал нийлэхгүй байна гэсэн?

-Зэрэглэл тогтоох “Стандарт энд Пурс” байгууллагынхан олон улсын бүх банкиг нэгээс 10 хүртэл үнэлж, ангилаад Монголыг есдүгээрт тавьсан байсан. Манайхны хөгжил дорой гэж үздэг Папуа Нью Гвиней, Камбожийн банкны салбартай биднийг тэнцүүлж тавьсан байсан. Бид үүнийг хүлээн зөвшөөрөх ёсгүй гэж би хувьдаа бодож байгаа. Тэгэхээр гаднынханд зөв ойлголт өгөх, зөв үнэлгээ авах тал дээр бид хүчээ нэгтгэх ёстой.

Манайх бодит байдал дээр дунд юм уу, дундаас арай дээгүүр төвшинд явж байгаа болов уу гэж би хувьдаа бодож байна. Олон улсын хөндлөнгийн аудитын байгууллагууд манай банкуудыг шалгаад санхүү бүртгэл, банкны үйл ажиллагаа нь олон улсын журмын дагуу явж байна гээд баталгаажуулаад өгчихсөн байгаа. Дээр нь манай банкууд эхнээсээ олон улсын зах зээлд гарч байгаа шүү дээ. Дэлхийн зах зээл дээр үнэт цаас, бонд арилжаад, их хэмжээний мөнгийг Монголын эдийн засаг руу оруулж ирж байгаа. Энэ нь гаднын зах зээлийн итгэлийг улам бүр олж байна гэсэн үг.

-Зээлийн мэдээллийн хууль батлагдаж, Зээлийн мэдээллийн сан, төвтэй болох нь ямар ач холбогдолтой вэ?

-Зээлийн мэдээллийн сангийн гол зорилго нь иргэн бүр зээлийн үнэлгээгээ хийлгэж, тус тусын оноотой болох асуудал байгаа. Одоо чи бид хоёр л гэхэд зээлийн мэдээллийн санд холбогдох мэдээллээ бүртгүүлснээр тодорхой оноо авах юм. Тэр оноог зээлдэгч байгууллагууд үзээд, зээлийг шуурхай олгох өргөн боломж нээгдэх юм. Зээлийн мэдээллийн хуулиар хамгийн гол нь зээлийн мэдээллийг хэн, хэрхэн цуглуулах вэ, ард иргэдэд хэрхэн тараах вэ гэдэг зохицуулалтыг хийж өгсөн байгаа. Анх удаа гарч байгаа хууль. Энэ хууль гарснаар зээлийн мэдээллийн тогтолцоо бүрдэх үндсийг тавьж байгаа. Мэдээлэл гэдэг маань өөрөө үнэ цэнэ бүхий хөрөнгө шүү дээ. Энэ мэдээллийг хувь хүн, өрх гэр, компани, аж ахуйн нэгжүүд ашиглах боломжтой. Өөрийн зээлийн сайн түүхийг үүсгэн, зээлийн мэдээллээ үнэлүүлээд оноо авдаг болно. Өндөр оноо авах тусам банк санхүүгийн байгууллагатай харилцахад хялбар болно. Бичил, жижиг зээл авахад заавал барьцаа баталгаа шаардлагагүй болох, шууд зээл олгох тогтолцоо бүрдэх юм.

-Эдийн засагч хүний тань хувьд Монголын эдийн засгийн өнөөгийн байдалтай холбоотой хэдэн асуудалд байр суурийг тань сонсмоор байна. Монголбанкны дэд ерөнхийлөгч байсны хувьд мөнгөний бодлогын талаар та ямар бодолтой байгаа вэ. Сар гаруйн өмнө Монголбанк бодлогын хүүгээ чангаруулсан. Цаашид ч чангаруулах шаардлага бий гэж үзэж байгаа?

-Төсвийн хэт тэлсэн бодлого явж байхад онолын хувьд мөнгөний бодлогыг чангаруулна гэж байдаг. Тэгэхээр онолынхоо талаас зөв зүйтэй бодлого. Гэхдээ засч залруулах зүйл бас байна. Яагаад гэвэл бүх зээлийг хязгаарлаж, зээлийн нөхцөлийг хатууруулчихаж байгаа нь урт болон дунд хугацаанд Монголын эдийн засгийн үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг боогдуулж байна гэсэн үг. Тэгэхээр мөнгөний ялгавартай бодлого явуулах шаардлагатай гэж бодож байна. Хэрэглээний зээлийг хязгаарлаад, үйлдвэрлэл, үйлчилгээний зээлийг хязгаарлахгүй байх ёстой.

-Монголбанкны саналыг харгалзаж улсын төсвийг 1.1 их наядар танаж баталсан. Таны бодлоор инфляцыг 10 хувьд барих боломж хэр гарсан бол?

-Үгүй яах вэ. Би мөнгөний бодлогыг явуулах салбарт ажиллахгүй байгаа ч эдийн засагч хүнийхээ хувьд ярихад төсвийн зардлыг танана гэдэг инфляцыг бууруулахад үнэхээр тус дэм болно. Эерэг үр дагавар авчрах байх гэж найдаж байгаа. Гэхдээ энд зориуд хэлэхэд инфляцыг бууруулахын тулд манайх наад захын дотооддоо үйлдвэрлэж болох бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа.

-Жишээлбэл, 40-өөд сая малтайн хувьд сүү, махны үйлдвэрлэл нэн тэрүүнд яригдах байх?

-Яг тийм. Жилээс жилд хавар болохоор мах, сүү тасарчихдаг.Энэ үед мах, сүүний үнэ өсдөг. Дагаад инфляц нэмэгдлээ гэдэг. Яагаад энэ асуудал жил бүр ужиг болон давтагдаад байна вэ. Үйлдвэрлэл нь хөгжөөгүй болохоор л тэр. Манайд мах, сүүний хангалт дундад зууны үеийнхээрээ байна гэж хэлж болно. Намар цаг агаар хүйтрэхээр мах хөлдөх үед мал нядалдаг. Тэгээд нядалсан махаа өвөлдөө идэж барагдуулдаг. Хавар мах нь дуусдаг. Гэтэл зүй нь юу байх ёстой вэ гэхээр махны тогтвортой хангамжийг бий болгох, мах боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх. Ингэхийн тулд XXI зууны, орчин үеийн махны хөргүүрүүдийг бий болгох хэрэгтэй. Тэр хөргүүртээ махыг ангилаад, зэрэглээд орчин үеийн сав баглаа бодлоор боогоод тавьсан байх ёстой. Тэгээд зах зээлийг махаар тогтмол хангадаг чадвартай байх ёстой. Энэ бүхнийг бий болгохын тулд, дэмжихийн тулд үйлдвэрлэл үйлчилгээний зээлийг хязгаарлах ёсгүй. Одоогийнхоороо бүх зээлийг хязгаарлаад байвал энэ асуудал үргэжилсээр л байна.

-Тэгэхээр төрийн зохицуулалт дутаад байна гэж ойлгож болох нь ээ?

-Хамгийн гол нь ялгавартай бодлого явуулах ёстой. Жишээлбэл, хэт их зээл гараад эдийн засагт сөргөөр нөлөөлөөд байгаа үед мөнгөний бодлогын талаасаа зөвхөн хэрэглээний зээлийг хязгаарлая. Үйлдвэрлэл үйлчилгээний зээлийг хязгаарлахгүй байя. Тэгэхгүй бол мөнгөний хатуу бодлогоор түр зуур инфляцыг бууруулж болж байгаа ч уг сурвалж, инфляцын үндсийг таслаж чадахгүй байна.

-Хэдий Монголбанк мөнгөний бодлогоо чангаруулж байгаа ч ирэх онд банкууд зээлийн хүүгээ бууруулах боломж бий юү?

-Мөнгөний бодлого хатуурсан байгаа үед зээлийн хүүг бууруулах боломжгүй. Мөнгөний бодлогыг хатууруулна гэдэг маань Монголбанкны үнэт цаасны хүү нэмэгдэнэ гэсэн үг. Үүнийг дагаад арилжааны банкууд тэр үнэт цаасыг худалдаж авах илүү сонирхолтой болно. Яагаад гэвэл зүгээр сууж байгаад ашиг олох боломж нэмэгдэнэ шүү дээ. Тэгэхээр аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлд зээл өгснөөс Монголбанкинд бэлэн мөнгөө тушаагаад эрсдэлгүйгээр өндөр хүү авах боломж бүрдэж байна гэсэн үг. Тэгэхээр эдийн засагт эргэлдэж байх мөнгө Монголбанк руу орчихож байгаа юм. Энэ үйл явц эдийн засагт тус нэмэр болох юм ч биш л дээ.

-Банкууд зээлээ хязгаарласан, зарим нь бүр хаачихсан гэсэн яриа яваад байгаа. Тэгэхээр үүнтэй холбож ойлгож болох нь ээ?

-Аж ахуйн нэгж, иргэд, компанид очиж болох байсан зээлийн хөрөнгө хумигдаад Монголбанк руу явчихаж байгаа учраас зээл хумигдахаас өөр аргагүй болж байгаа юм. Гэхдээ энэ бол түр зуурын асуудал гэж ойлгох ёстой. Мөнгөний бодлого зөөлрөөд ирэхээр тэр хөрөнгийг эдийн засаг руу оруулах боломж дахиад нэмэгдэнэ л дээ.

-Цалинг 53 хувиар нэмэгдүүлэх нь эдийн засагт сөрөг нөлөөтэй гэж гадна, дотнын эдийн засагч шинжээч нар анхааруулж байгаа. Гэвч багш нараас эхлээд жагсч, эмч нар ч нэгдээд байна. Таны бодлоор үүнийг зохицуулах арга зам юу байна?

-Монголын эдийн засагт өөрсдөө үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдээгүй байхад эргэлдэж байгаа мөнгөний хэмжээ нэмэгдээд байхаар тэр хэмжээгээр үнэ өсөөд байдаг. Тэгэхээр цалин нэмсэн ч нэмэргүй байдаг. Тэр бол бүх нийтэд ойлгомжтой зүйл. Шинэ зүйл ч биш. 1990 оноос энэ үзэгдэл байнга давтагдаж байгаа. Мөнгөний нийлүүлэлт нэмэгдээд л байх юм бол (хоосон мөнгөний нэмэгдэл гэж ярьдаг) үнэ өснө. Нөгөөтэйгүүр багш, эмч нарын цалин дэндүү доогуур байгаа гэдэг үнэн. Тэгэхээр багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэх нь зөв гэж бодож байгаа. Ядаж амьдралаа залгуулах хэмжээнд хүргэх ёстой. Багш, эмч нар бол нийгэм, эдийн засагт урт хугацааны хөрөнгө оруулалт хийж байгаа хүмүүс. Харин яам, агентлагуудад байгаа өчнөөн олон үр бүтээл багатай төсвийн ажилчдын тоог цөөрүүлэх ёстой. Одоо 150 мянгаад төрийн албан хаагч байна гээд байгаа. Энэ бол цөөн хүн амдаа харьцуулбал дэндүү өндөр тоо. Тэгэхээр үр бүтээл багатай, бүр үр бүтээлгүй төрийн албан хаагчдын тоог цөөрүүлээд оронд нь багш, эмч нарын цалинг нэмэх замаар зохицуулалт хийх боломжтой.